



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№112 /556/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.07.20

Цаг үе, үйл явдал

"НҮҮДЭЛЧИН ЗААН-2023" ХАМТАРСАН СУРГАЛТ, ДАДЛАГА ЭХЭЛЛЭЭ



Монгол, Энэтхэг хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцааг бэхжүүлэх зорилго бүхий 15 дахь удаагийн "Нүүдэлчин заан" цэргийн хамтарсан сургалт, дадлагын нээлтийн үйл ажиллагаа өнөөдөр боллоо.

оролцож байна.

Сургалт, дадлагыг нээж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлсэн үгэндээ "Монгол, Энэтхэг хоорондын дипломат харилцаа 70 орчим жилийн арвин их түүхтэй. Тэр дундаа хоёр улсын стратегийн түншлэлийн харилцаанд батлан хамгаалах салбарын

Үргэлжлүүлэн БНЭУ-аас Монгол Улсад байгуулж байна. Энэ нь хоёр суугаа Элчин сайд М.П.Сингх хэлсэн улсын батлан хамгаалах салбар үгэндээ "Хоёр улс маань өнө эртнээс хоорондын хамтын ажиллагаа



7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 15 хоногийн хугацаанд үргэлжлэх энэхүү сургалт, дадлага нь томилгоот бүрэлдэхүүн орон тооны хүч хэрэгслээр үндсэн үүрэг гүйцэтгэх, түүнд дэмжлэг үзүүлэх ажиллагаанд бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, харилцан

хамтын ажиллагаа голлох байр эзэлж байдаг сэтгэл хангалуун байдаг. Өнгөрсөн онд БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх Монгол Улсад айлчилж, миний бие БНЭУ-д хариу айлчилсан нь бидний харилцаа, хамтын ажиллагааг нэгэн шинэ шатанд гаргаж, ойрын ирээдүйд хэрэгжүүлэх олон ажил арга хэмжээний эхлэл болсон. Тэгвэл энэ өдөр тэдгээр олон ажил, арга хэмжээний нэг нь болох цар тахлын улмаас



туршлага солилцох замаар үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Уг сургалт, дадлагад Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Тусгай хүчний цэргийн харьяа Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 084, 150, 330, 350 дугаар ангиуд, БНЭУ-ын талаас Жаму болон Кашмирын нэгдүгээр явган цэргийн батальоны цэргийн алба хаагчид

завсардаад байсан хоёр орны тусгай хүчний хамтарсан "Нүүдэлчин заан" сургалт, дадлага ахин сэргэж нээлтийн арга хэмжээг зохион байгуулж буйд баяртай байна. Бид тус сургалт, дадлагыг 15 дахь жилдээ хамтран зохион байгуулж байгаа нь хоёр орны цэргийн харилцаа, хамтын ажиллагааны бахархал мөнөөс мөн. Хамтарсан сургалт, дадлагаар хоёр улсын цэргийн алба хаагч нар харилцан бие биеэсээ суралцаж, шаардлагатай цагт дэлхийн хаана ч хамтдаа үүрэг гүйцэтгэх бэлтгэлтэй болно гэдэгт итгэлтэй байна" гэлээ.



түүх, соёл, оюун санааны хэлхээтэй явж ирсэн. Тэр дундаа сүүлийн жилүүдэд хоёр улсын Батлан хамгаалах салбар хоорондын гадаад хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж буйд баяртай байна. Саяхан болж өнгөрсөн "Хааны өндөр түвшинд хөгжиж буйг харуулсан явдал боллоо" хэмээгээд Батлан хамгаалахын сайд нарын харилцан айлчлалын үеэр БНЭУ-аас Монгол Улсад буцалтгүй тусламж үзүүлэхээр



эрэлд-2023" энхийг дэмжих ажиллагааны яригдаж байсан эмнэлгийн олон улсын сургуульд БНЭУ-ын талаас түргэн тусламжийн машин, 40 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн баг хүйтний улирлын тусгай хувцас оролцсон. Товчхондоо бид бүхэн нэг хэрэглэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт гардуулан багийн хамтарсан сургуулийг зохион өглөө.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,427	3,435
EUR 🇪🇺	3,770	3,798
CNY 🇨🇳	477	482
RUB 🇷🇺	38	38.30
JPY 🇯🇵	23.20	24.70
KRW 🇰🇷	2.63	2.65

ЗУРХАЙ




2023.07.20 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 3

ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал баялаг төгөлдөр болно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.14-20.43
Барилдлага:
Хүчин төгсөх
ШҮТЭН БАРИЛДАГА:
Авахуй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,200,574

Эдгэрсэн

Нийт: 664,012,856

Нас барсан

Нийт: 6,903,800

Цахим шууданд

ЗХЖШ-ЫН МАТЕРИАЛ, ТЕХНИКИЙН ГАЗРЫН ХАРЬЯА АНГИУДЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САХИЛГЫН ДҮНГ ГАРГАЛАА



төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа Ч.Ариунболд болон Зэвсэгт хүчний 011, 015, 089, 232, 310, 314, 334 дүгээр ангиудын Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга нар оролцлоо.

Материал, техникийн газрын даргын орлогч, штабын дарга хурандаа Ц.Батсайхан газрын харьяа ангиудын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн 2023 оны эхний хагас жилийн тайлантай танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар харилцан санал солилцож, үүрэг чиглэл өгөв.

Мөн ЗХЖШ-ын Материал, техникийн газар, Төрлийн цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын материал, техникийн хэлтэс, Материал, техникийн газрын харьяа Зэвсэгт хүчний 011, 015, 089, 232, 310, 314, 334 дүгээр ангиудын удирдлага, штаб, байлдааны үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүдтэй явуулах нэгдсэн команд-штабын хээрийн сургууль, тусгай тактикийн хээрийн сургуулийн зохион байгуулалтын зааврын урьдчилсан байдлаар танилцуулж, бэлтгэл ажлыг хангах талаар үүрэг чиглэлээр хангаж ажиллалаа.

ЗХЖШ-ын Материал, техникийн газрын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн 2023 оны эхний хагас жилийн дүнгийн хурал 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдөр Материал, техникийн газрын сургалтын танхимд боллоо.

Тус дүнгийн хуралд Материал, техникийн газрын даргын орлогч, штабын дарга хурандаа Ц.Батсайхан, штабын удирдлага,

ТЭСРЭЭГҮЙ ҮЛДСЭН 6 НЭР ТӨРЛИЙН 113 ШИРХЭГ ГАЛТ ХЭРЭГСЛИЙГ УСТГАЖ, АЮУЛГҮЙ БОЛГОЛОО



Дорнод аймгийн Засаг даргын хүсэлтийн дагуу ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн инженер хайгуулын бүлэг Дорнод аймгийн Хэрлэн болон Баянтүмэн суманд ажиллаж, 6 нэр төрлийн 113 ширхэг тэсрээгүй үлдсэн галт хэрэгслийг устгаж, аюулгүй болголоо.

Хуучин ЗХУ-ын цэргийн нэгтгэл, ангийн хээрийн сургуулилт хийж байсан талбайд тэсрэлгүй, газрын хөрсөнд үлдсэн галт хэрэгслүүдийг илрүүлж, устгах ажлыг

жил бүр гүйцэтгэдэг бөгөөд энэ жил дөрвөн бүлгээр хоёр суманд ажиллаж, иргэдийн амь нас, эд хөрөнгөд учирч болох эрсдэлийг бууруулж чадсан юм.

Энэ ташрамд, Дорнод нутгийн иргэд та бүхэн тэсэрч дэлбэрч болзошгүй байлдааны сум, бусад галт хэрэгслийн талаарх мэдээллийг аймгийн Цагдаагийн газарт өгч, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зөвлөж байна.

Ахлах дэслэгч Л.МӨНХЧӨДӨР

"НЭГ ЗАМ НЭГ СОЁЛ" НӨЛӨӨЛЛИЙН АЯНЫ ХҮРЭЭНД...



Мөн аяны хүрээнд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн тээврийн бүлгийн 7 нэгж техник УБ-Архангай аймгийн Өгий нуур чиглэлд хөдөлгөөн үйлдэх үед техникийн бүрэн байдлыг хангуулах, жолооч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж, баталгаа авч аянд нэгдүүлэн зурагт хуудсыг техникүүдэд байрлууллаа.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас "Орон нутгийн хөдөлгөөний-Соёл 2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд "НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ" нөлөөллийн арга хэмжээг иргэд жолооч нарт сурталчлах зорилгоор Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэр Гордокийн урд замд зүүн аймгуудын чиглэлд явж байгаа тээврийн хэрэгслүүдэд

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах техникийн бүрэн бүтэн байдал, гадна талын гэрэлтүүлэг хэрэгсэл, дагалдах хэрэгсэл, бичиг баримтыг үзэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж иргэд, жолооч нарт аяны ач холбогдлыг таниулах, зурагт хуудас /стикер/-ыг тээврийн хэрэгсэлд нь байршуулан ажиллалаа

НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2023-2024 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан (офицер), цэргийн мэргэжилтний (цэргийн ажиглагч, холбогч офицер) сонгон шалгаруулалтыг 2023 оны 09 дүгээр сарын 04-нөөс 09 дүгээр сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ.

Үүнд: 1.

- Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
- Ажил байдлын тодорхойлолт;
- Жолооны үнэмлэхийн хуулбар;
- Гадаад паспортын хуулбар;
- Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
- Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
- Товч судалгаа (доорх хүснэгтийн дагуу бөглөх);

Анг	Албан тушаал	Цол	Өвг нэр	Нас, хүйс	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа төгссөн байдал	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон өгнөө	ЭЗАН-д үүрэг гүйцэтгэсэн байдал	Англи хэлний түвшин тогтоох шалгалтын өгнөө (Хамгийн сүүлд өгсөн ALCPRT, ECL, TOEFL, IELTS)
-----	--------------	-----	---------	-----------	--	-------------------------------------	--	---------------------------------	---

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэс psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3679, 99732447, 88689855, 70152660/-тай холбогдож тодруулна уу. "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmf.gov.mn/gsmf/cat/60> холбоосоор орж танилцана уу.

ЗХЖШ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ, ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Гэрэл зураг түүх өгүүлнэ



"ОЮУТАН ЦЭРЭГ-2023"